

МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2026-04-15

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн гудамж, Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдав. Хурлыг танхим цахим хосолсон хэлбэрээр компанийн албан ёсны фэйсбүүк группээр шууд дамжуулалт хийн хувьцаа эзэмшигчдийг зайнаас оролцох боломж нөхцлийг ханган хуралдав.

Эхэлсэн цаг: 14:00

Дууссан цаг: 16:30

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү

Тооллогын комисс: дарга П.Энхбаяр, гишүүд Ц.Дөлгөөнмайдар, М.Тамир

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. Компанийн 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлэх,
4. ТУЗ-ийн 2026 оны төсвийг хэлэлцүүлэх

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Н.Улаанхүү хурлыг нээж, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов”-ыг зарласан 2026 оны 3 сарын 4 өдрийн 26/11 тоот ТУЗ-ийн тогтоолоор томилогдсон Тооллогын комиссыг танилцуулан, хурлын ирцийг танилцуулахаар тооллогын комиссын дарга П.Энхбаярыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр: Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 312,946,074 ширхэг хувьцаа буюу 76.54%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлж, зайнаас холбогдсон, танхимд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын үйл ажиллагааг эхлүүлэв.

Хурлын дарга Н.Улаанхүү нээлтийн үг хэлж, хурлын дэгийн төслийг танилцуулан, хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн ил санал хураалтаар дэгийг батлав. Дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь Монос Хүнс ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. (Тайлангийн бичлэгийг тэмдэглэлд хавсаргав. <https://www.facebook.com/MonosFoods/videos/1006021301898759>)

Танилцуулах асуудал 1: Хурлын дэгийн дагуу Онч аудит ХХК-ийг төлөөлөн партнер Б.Уранбилэг Монос Хүнс ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компани Онч аудит ХХК-аас гаргасан дүгнэлтийг танилцуулав.

Танилцуулгад: Онч аудит ХХК-ийн товч мэдээлэл, багийн бүрэлдэхүүний хараат бус байдлаа ханган ажилласан талаар болон санхүү тайлангийн аудитын зорилго, НББ-ийн бодлогын сонголт, тооцоолол, аудитын дүгнэлтийн товч агуулга, аудитын гол асуудлууд, зөвлөмж хүргүүлсэн илрүүлэлтийн талаар мэдээлж танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ын дарга Х.Ананд ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн 2025 онд хийсэн ажлын тайлан, хурлын мэдээлэл зэргийг товч танилцуулж, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг эх хувиар нь уншиж танилцуулав. Танилцуулгад: ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, 2025 онд ТУЗ ээлжит хурал 4, ээлжит бус хурал 5, тогтоол 27 гарсан талаар тайлагнав. Мөн хороодын хурлын талаар, 2025 онд шийдвэрлэсэн голлох шийдвэрүүдийн талаар тайлагнав.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн, хурлын дарга Н.Улаанхүү 2026 оны ТУЗ-ийн төсвийн төслийг танилцуулав.

Танилцуулгад: 2026 оны төсвийг нэмэгдүүлж танилцуулсан бөгөөд нэмэгдэх шалтгаануудыг дурдаж хурлын зардал 12 сая, хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал 30 сая, гишүүд цалин 348 сая, сургалтын зардалд 5 сая нийт 395 сая төгрөгийн төсвийг батлуулахаар санал оруулсан.

Танилцуулах асуудал 2: Хурлын дэгийн дагуу хурлын дарга Н.Улаанхүү 2026 оны 02 сарын 16 өдрийн 26/01 тоот тогтоолоор батлагдсан “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр цахимаар санал хураах зааврыг дэлгэц дээр танилцуулав.

Хурлын дарга Н.Улаанхүү: Санал хураалт өгч байх хугацаанд хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхлэж байна. Танхимаас, мөн цахимаар асуусан асуултад ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын багаас хариулахболно гэснээр асуулт хариултын цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултанд Гүйцэтгэх захирал А.Отгондарь, ТУЗ-ын дарга Х.Ананд, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү, Г.Золжаргал нар хариулт өгөв.

Хурлын дарга Н.Улаанхүү: Дэгийн дагуу асуулт хариултын цаг дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулна уу гээд тооллогын комиссын дарга П.Энхбаярыг урья.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр Тооллогын комиссын тогтоол №02 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийг үндэслэн санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг нэгтгэн танилцуулсныг доор дэлгэрүүлбээс:

Батлах асуудал 1: “Монос Хүнс ХК-ийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 312,154,778 ширхэг буюу 99.99% ;
2. Татгалзсан – байхгүй ;
3. Түдгэлзсэн – 1,906 ширхэг буюу 0.001% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй- байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 2: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 311,777,225 ширхэг буюу 99.88% ;
2. Татгалзсан – 367,658 ширхэг буюу 0.12 % ;
3. Түдгэлзсэн – 11,801 ширхэг буюу 0.004% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй гэсэн тогтоол уншиж танилцуулав.

Хурлын дарга Н.Улаанхүү: Санал хураалтын дүнд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах 01, 02 дугаарт тогтоолыг уншиж танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 16 цаг 30 минутанд дуусав.

Тэмдэглэл хянасан:

Хурлын дарга..... Н.Улаанхүү

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга..... Н.Цагаанхүү